

СОНГУУЛИЙН НЭГДСЭН ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД АНХААРАХ ЗАРИМ САНАЛ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛИЙН ТАЛААР

1. “Хорих газар ял эдэлж байгаа” гэсэн ойлголтыг “шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор хорих болон баривчлах ял эдэлж байгаа, хорих болон баривчлах ял эдлэхээс зайлсхийж яваа, хорих байгууллагаас түр чөлөөгөөр гарсан иргэнийг нэгэн адил хамааруулна.” гэж томъёолох.

2. Сонгуулийн автоматжуулсан системийг сонгуулийн үйл ажиллагаанд хэрэглэж байгаатай холбоотойгоор автоматжуулсан системийн иж бүрдлийг бэлтгэх болон сонгуулийн бусад бэлтгэл ажилтай холбоотойгоор сонгуулийг санал авах өдрөөс 65-с доошгүй хоногийн өмнө товлон зарлахаар тогтоож, хуульчлах нь зүйтэй юм.

3. Сонгуулийн хороод сонгуулийг хуулийн дагуу зохион байгуулах, сонгогчдын боловсролын асуудалд анхаарал хандуулж, хангалттай мэдээлэл олгохын тулд хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах зэрэг эрх зүйн өөрчлөлтийг боломжит цаг хугацаанд, дор хаяж нэгээс доошгүй жилийн өмнө хийж байх нь анхаарах асуудлын нэг юм. Иймд УИХ-аас сонгуулийн хууль тогтоомжийг ээлжит сонгуулийн жил эхлэхээс 1-ээс доошгүй жилийн өмнө баталж, сонгуулийн бэлтгэл хангаж ажиллах хангалттай хугацааг гаргаж хуульчлах нь зүйтэй байна. Ингэснээр Сонгуулийн Ерөнхий Хорооноос сонгуулийн хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх арга хэмжээ авах, холбогдох журам, зааврыг боловсруулж батлах, сонгуулийн хороодод ажиллах хүмүүст сургалт семинарыг хүртээмжтэй зохион байгуулах, сонгуулийн техник хэрэгсэл, програм хангамжийг шалган туршиж баталгаажуулах, сонгуулийн төв болон орон нутгийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэд олон нийт болон сонгогчдод сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлан таниулах зэрэг ажлыг зохион байгуулахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Хоёр. СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БҮРЭН ЭРХИЙН ТАЛААР

4. Сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид хэсэг байгуулахдаа Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг харгалзаж, сонгуулийн хэсгийг ээлжит сонгуулийн жилийн 2 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө байгуулахаар хуулийн төсөлд тусгах.

5. Сонгуулийн хороодыг тойргийн хороо, нутаг дэвсгэрийн хороо, салбар хороо, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо гэх мэт сонгууль болгоноор өөр өөрөөр нэршүүлж байсныг нэг мөр болгох. Сонгуулийг улсын хэмжээнд Сонгуулийн Ерөнхий Хороо, аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, сум, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд сум, дүүргийн сонгуулийн хороо, хэсэгт сонгуулийн хэсгийн хороо /цаашид “хэсгийн хороо” гэх/ тус тус зохион байгуулж явуулна гэж хуульчлах нь зүйтэй.

6. Сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд ажиллах төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын судалгааг ямар субъектээс гаргуулан авах, тэдгээр албан хаагчдад тавигдах шалгууруудыг хуульчлах.

7. Сонгуулийн хороод нь Сонгуулийн Ерөнхий Хорооноос баталсан хуралдааны дэгийг баримтлах ба гишүүдийн ажил үүргийн хуваарийг өөрөө тогтооно гэж хуульчлах. Түүнчлэн сонгуулийн хороодын ажлын зохион байгуулалтыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу хуульчлах. Энэ нь бүх шатны сонгуулийн хороодын үйл ажиллагаа нэг ижил дэгээр зохицуулагдах боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой.

Гурав. НЭР ДЭВШҮҮЛЭХ, НЭР ДЭВШИГЧИЙГ БҮРТГЭХ ТАЛААР

8. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Нам, эвсэл Улсын Их Хурлын сонгуульд 76-аас илүүгүй хүнийг тухайн нам, эвслийн гаргасан дарааллын дагуу нэрийн нэг жагсаалтаар нэр дэвшүүлнэ.” гэж,

Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 26.1-д “Нам, эвсэл нь сонгуульд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10.2-10.4-т заасан тухайн аймаг, сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тооноос илүүгүй хүнийг нэгдсэн нэг жагсаалтаар нэр дэвшүүлнэ.” гэж тус тус хуульчилсан.

Санал: Нам, эвслээс жагсаалтаар нэр дэвших процесс болон, нэр дэвшигчид тавигдах болзол, шаардлагыг сонгогчдод ил тод болгох хуулийн нарийвчилсан зохицуулалт шаардлагатай. Жишээ нь: Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.2-д “нэр дэвшүүлэхдээ тухайн хүний Улсын Их Хурлын гишүүн байх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвар, эх орон, ард түмний тусын тулд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалан бэхжүүлэх төгс эрмэлзэл, шударга ёс, хууль дээдлэх ёс, Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх чадварыг харгалзан үзэх; гэж заасан. Хуулийн энэ шаардлагыг тухайн нэр дэвшигч хангаж байгаа эсэхийг нэр дэвшүүлж буй нам, эвсэл хэрхэн үнэлж, дүгнэж буй нь тодорхой бус байдаг.

9. Холбогдох сонгуулийн хороо бие даан нэр дэвшигчийн дэмжигч сонгогчдын гарын үсэг зуруулах маягыг тэмдэг дарж олгодог байх. Энэ нь нэр дэвшүүлэх ажиллагаа нэг цаг хугацаанд зэрэг эхлэх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой.

10. Нэр дэвшүүлэх ажиллагааг сонгууль товлон зарласан өдрөөс хойш 10 хоногийн дараа эхлүүлж, 7 хоногийн хугацаанд дуусгахаар тооцож хуульчлах. Учир нь сонгуулийг сонгуулийн автоматжуулсан системээр зохион байгуулж буй тохиолдолд саналын хуудаст нэр дэвшигчдийн нэрийг байрлуулах, нэр дэвшигчдийн нэрийг санал тоолох төхөөрөмжид программчлах, программ хангамжийг туршин шалгах ажиллагаанд хугацаа шаардлагатай юм.

11. Саналын хуудсанд нэр дэвшигчдийн нэрийг Улсын Их Хуралд болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хамгийн олон суудал авсан намын нэр дэвшигчээс эхлэн дараалуулж бичих бөгөөд хамтарсан нам, эвслийн хувьд Улсын Их Хуралд болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хамгийн олон суудал авсан намын суудлын тоог баримтлан дараалалд оруулна гэж хуульчлах. Харин суудал аваагүй эсхүл шинээр бүртгэгдсэн намын хувьд Улсын дээд шүүхэд бүртгэгдсэн дарааллыг баримтлах.

12. Намын жагсаалтаар нэр дэвшүүлэх үйл ажиллагааг сонгогчдод ил тод болгох, сонгогч жагсаалтаар нэр дэвшигчдийг эрэмбэлэх боломжтой байхаар хуульчлах. Тодруулбал: намын жагсаалтаар нэр дэвшигчдийг тухайн нэр дэвшүүлсэн нам, эвслээс дараалалд оруулахгүй бөгөөд жагсаалтаар нэр дэвшигчдийг сонгогч өөрийн сонголтоор дараалалд оруулна. Ингэснээр хууль тогтоох болон нутгийн удирдлагын байгууллагад сонгогчдын бодит төлөөлөл сонгогдох боломж бүрдэх юм. Уг асуудлаар Улсын Их Хурлын сонгууль болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн үеэр иргэд, сонгогчдоос санал хүсэлт олноор ирсэн болно.

13. Нэгдсэн нэг жагсаалтаар нэр дэвшиж байгаа тохиолдолд 1 нэр дэвшигч уг жагсаалтад 1 бичигдэх гэж хуульчлах. Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын 2012 оны сонгуулиар зарим аймагт 1 нэр дэвшигч тойрогт болон жагсаалтаар зэрэг нэр дэвших тохиолдол гарч байсан.

Дөрөв. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЛААР

14. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-т “Нам, эвслээс нэр дэвшигч нь санал хураалт дууссан өдрөөс хойш 15 хоногт багтаан өөрийн сонгуулийн зардлын тайлангаа нам, эвсэлдээ гаргаж өгөх бөгөөд нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайланг санал хурааж дууссан өдрөөс хойш нэг сарын дотор гаргаж, Сонгуулийн Ерөнхий Хороонд ирүүлнэ.” гэж,

Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т “Нам, эвслээс нэр дэвшигч нь санал хурааж дууссан өдрөөс хойш 15 хоногт багтаан өөрийн сонгуулийн зардлын тайлангаа нам, эвсэлдээ гаргаж өгөх бөгөөд нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайланг санал хураалт дууссан өдрөөс хойш 20 хоногийн дотор гаргаж аймаг, сум, дүүргийн сонгуулийн хороонд ирүүлнэ.” гэж,

Харин Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д “Намын сонгууль эрхэлсэн байгууллага санал хураалт дууссан өдрөөс хойш 30 хоногт багтаан нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлан /цаашид “зардлын тайлан” гэх/-г гаргаж Сонгуулийн Ерөнхий Хороонд ирүүлнэ.” гэж хуульчилсан.

Санал: Нэр дэвшигч болон намын сонгууль эрхэлсэн байгууллага хуульд заасан хугацаанд багтаан сонгуулийн зардлын тайланг гаргаж холбогдох сонгуулийн байгууллагад хүргүүлээгүй бол хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх. Ингэснээр сонгуульд оролцож буй нэр дэвшигч, болон нам, эвсэл, хамтарсан намаас сонгуульд оролцох соёл болон хариуцлагыг сайжруулах боломжтой гэж

үзэж байна. Жишээ нь: Улсын Их Хурлаас 2005 онд баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн /хүчингүй болсон/ 26 дугаар зүйлийн 26.3.6-д өмнөх сонгуулийн зардлын тайланг санал хурааж дууссан өдрөөс хойш 1 сарын дотор аудитын дүгнэлтийн хамт гаргаж Сонгуулийн Ерөнхий Хороонд ирүүлээгүй бол тухайн нам, эвслийг бүртгэхээс татгалзах үндэслэл болж байсан.

15. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлд сонгуулийг зохион байгуулахтай холбоотойгоор Улсын төсвөөс гарах зардлыг нарийвчлан тогтоож, Цагдаа болон Улсын бүртгэлийн байгууллагын төсөвт тусгахаар хуульчилсан. Хуулийн энэ зохицуулалт нь сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд хуульд заасны дагуу оролцож буй төрийн байгууллагуудаас гарах зардлыг зөв хуваарилахад чухал ач холбогдолтой байна. Иймд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн сонгуулийн зардалтай холбоотой хуулийн зохицуулалтад тулгуурлаж, нэгдсэн хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

16. Сонгуулийн тухай хуулиудад санал авах байрыг тухайн хэсгийн харьяалагдах сум, дүүргийн Засаг дарга хариуцаж бэлтгүүлэх бөгөөд сонгуулийн хороодын ажиллах болон санал авах байрыг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үнэ төлбөргүй гаргаж өгнө гэж хуульчилсан. Гэтэл зарим тохиолдолд тухайн хэсгийн харьяалж буй нутаг дэвсгэрт төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байхгүй тохиолдолд хувийн аж, ахуйн нэгжийн байрыг түрээсээр ашиглах тохиолдол гардаг. Энэ тохиолдолд хувийн аж, ахуйн нэгжийн байрыг түрээсээр ашиглах зардлыг сонгуулийн хуульд тусгаж хуульчлах нь зүйтэй.

17. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн хувьд ээлжит бус, нөхөн, дахин сонгуулийн зардлыг тухайн орон нутгийн төсвөөс гаргахыг хуульчлах.

18. Сонгуулиас сонгуульд сонгогчдын ирц тогтмол буурч байгаа билээ. Иймд сонгогчдын ирцийг нэмэгдүүлэх зорилгоор саналаа өгсөн сонгогчийг урамшуулдаг арга хэлбэрийг зөвшөөрч, түүнтэй холбогдох төсөв хөрөнгийг сонгуулийн зардлын төсөвт хуваарилдаг байх зохицуулалтыг хуульчлах.

Тав. СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТЫН ТАЛААР

19. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2-т “Сонгогчийн шилжилтийг санал авах өдрөөс 30 хоногийн өмнө зогсоох бөгөөд хэсгийн хороо санал авах өдрөөс 30 хоногийн дотор аливаа сонгогчийн шилжилтийг бүртгэхийг хориглоно.” гэж,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т “Сонгогчийн шилжилтийг санал авах өдрөөс арав хоногийн өмнө зогсоож, сонгогчийн шилжилтийг бүртгэхийг хориглоно.” гэж тус тус заасан.

Санал: Сонгогч хуулийн хугацаанд шилжих хүсэлтээ гаргасан боловч шилжилтээ бүртгүүлэхэд хуульд заасан хугацаа өнгөрөх тохиолдол гардаг. Иймд сонгогч шилжилтээ бүртгүүлэх хугацааг хуульчлах нь зүйтэй. Сонгуулийн үеэр бүх шатны сонгуулийн хороодод ажиллаж байгаа төрийн албан хаагчид болон цагдаагийн албан хаагчид, улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүд, хэсгийн хорооны дэргэдэх мэдээллийн технологийн даамлаар ажиллаж байгаа иргэдийн сонгох эрхийг хангах зорилгоор тухайн албан хаагчдыг ажиллуулж байгаа сонгуулийн хороо тэдгээрийг сонгуульд оролцох боломжоор хангаж, шилжилт хөдөлгөөнийг хуулийн дагуу зохион байгуулах үүрэгтэй байх.

20. Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн боловч санал хураалт болох өдөр сонгогч өөр газарт байх тохиолдол их гардаг. Сонгуулийг нэгэнт автоматжуулсан системээр зохион байгуулж буй тохиолдолд сонгогч санал авах өдөр өөрийн харъяа сонгуулийн хэсэгт саналаа өгөх боломжгүй тохиолдолд урьдчилан санал авах талаарх хуулийн зохицуулалттай байх нь цаашид анхаарах асуудал болж байна. Эсхүл мэдээллийн технологийн ололтод түшиглэн сонгогч хаана байхаас үл хамааран /Монгол Улс дотроо/ байгаа газраа сонгуульд оролцох боломжийг бусад өндөр хөгжилтэй орны туршлагаас судлах.

21. Сонгогчдын нэрийн жагсаалтад тухайн хэсгийн нутаг дэвсгэрт хаягийн бүртгэл бүхий сонгогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаягийг бүртгэх бөгөөд ийнхүү бүртгэхэд уг мэдээлэл тухайн сонгогчийн биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-өөр хянагдсан байх ба сонгогчдыг тухайн хэсэг дэх сонгогчдын хаягийн бүртгэлийн дагуу дараалуулан бичнэ гэсэн нэг томъёоллоор хуульд тусгах.

22. Сонгогчдын шилжилт хөдөлгөөн эхлэхээс өмнө сонгогчийн бүртгэлийн үйл ажиллагааг хөтлөх иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудыг сонгуулийн хэсгийн хороодод томилон ажиллуулахаар хуульчлах. Учир нь өмнөх сонгуулиудаар сонгогч шилжих хуулийн хугацаа эхэлсэн байхад шилжүүлэг хийх, сонгогчийн бүртгэл хөтлөх үүрэг бүхий иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан томилогдоогүй гэх шалтгаанаар тухайн сонгогч шилжилт хөдөлгөөнөө хийлгэж чадаагүй тохиолдлууд гарч байсан. Үүнээс шалтгаалан сонгогч сонгох эрхээ эдэлж чадахгүйд хүрч байв.

Зургаа. СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР

23. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар нэр дэвшигч сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сонгогчдын саналыг эд бараа, мөнгө, үнэ төлбөргүй үйлчилгээ, эд хөрөнгө, эрх олгох тухай амлалт өгөх зэрэг сонгогчдын саналыг хууль бусаар татах арга, хэрэгслүүдийг хориглосон нь сонгуулийн менежментийг шинэ шатанд гаргасан зохицуулалт болсон. Гэсэн хэдий ч хуулийн зохицуулалтыг илүү оновчтой, нарийвчлан зохицуулах шаардлага байгаа юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар сонгуулийн мөрийн хөтөлбөр, сурталчилгаа явуулах арга хэрэгслийг илүү дэлгэрэнгүй, нарийвчилсан

зохицуулалттай болгож хуульчилснаар сонгуулийн сурталчилгаатай холбоотой элдэв гомдол, маргаан урьд урьдын жилүүдэд явагдсан сонгуулиудаас эрс буурсныг дурдах нь зүйтэй. Иймд цаашид сонгуулийн нэгдсэн хуулийн төсөл боловсруулахад Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, сурталчилгааг зохицуулсан хуулийн зохицуулалтуудыг баримтлах нь зүйтэй гэж үзэж байна.

24. Нэр дэвшигчдээс томилсон ухуулагч, шадар туслагч нар сонгуулийн санал хураалтын өдөр санал хураах байранд ажиглагчаар томилогдон ажиллах тохиолдолд санал хураах байранд аливаа ухуулга, сурталчилгаа явуулахыг хориглохоор хуульчлах нь зүйтэй. Учир нь нэр дэвшигчдийн ухуулагч, шадар туслагчаар томилогдсон этгээд санал авах байранд ажиглагчаар томилогдсон тохиолдолд санал хураах байрны гадаа ухуулга, сурталчилгаа явуулах, санал хураах байранд орж ажиглалтын үйл ажиллагаа явуулах зэрэг 2 төрлийн статустайгаар үйл ажиллагаа явуулах нь сонгууль зохион байгуулах ажлыг эмх замбараагүй болгох шалтгаан болдог.

25. Сонгуулийн Ерөнхий Хороо нь намын сонгууль эрхэлсэн байгууллагын улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах ажилтаныг бүртгэж, үнэмлэх олгоно. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь намын сонгууль эрхэлсэн байгууллагын аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах ажилтаныг бүртгэж, үнэмлэх олгоно. Сум, дүүргийн сонгуулийн хороо нь намын сонгууль эрхэлсэн байгууллагын сум, дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах ажилтаныг болон нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагчийг тус тус бүртгэж, үнэмлэх олгоно. гэж хуульчлах. Учир нь сонгуулийн үеэр Сонгуулийн Ерөнхий Хороо болон бүх шатны сонгуулийн хороодын ажлын ачааллыг зөв, оновчтой зохион байгуулахад ач холбогдолтой байдаг.

26. Нам, эвсэл, нэр дэвшигчид зөвхөн сонгуулийн мөрийн хөтөлбөр, сурталчилгаагаа сонгогчдод хүргэх зорилгоор бага үнэтэй сурталчилгааны эд зүйлсийг тодорхой тоо, хязгаартайгаар хүргэхийг зөвшөөрөх. /үзэг, бал, бөмбөлөг, тор, уут, аяганы тавиур, cd диск гэх мэт./

27. Сонгуулийн мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг төрийн аудитын байгууллагаар хянуулсан байхаар хуульчлах.

28. Нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаагаа цаг хугацааны хувьд нэгэн зэрэг эхлэх нөхцөл, боломжийг хуульчлах. Тухайлбал, сонгуулийн сурталчилгааг нэгэн зэрэг эхлүүлэх зорилгоор нэр дэвшигчийн үнэмлэхийг нэг өдөр зэрэг олгодог байхаар хуульчлах.

29. Нам, эвсэл, хамтарсан нам, бие даан нэр дэвшигчдээс нэг хэсэгт тус бүр 4 хүртэл сонгуулийн ажиглагчийг томилж ажиллуулах эрхтэй байх. Ажиглагчид сонгуулийн хэсэгт ажиллах хуваариа тухайн хэсгийн хороонд гаргаж өгч, түүний дагуу ажиглалтаа явуулах гэж хуульчлах. Ингэснээр санал авах байранд ажиглалт

явуулж буй субъектүүдийн зүгээс гаргадаг аливаа эмх, замбраагүй байдлыг цэгцлэх ач холбогдолтой юм.

30. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг радио, телевизээр төлбөртэй нэвтрүүлэх сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг нэр дэвшигч бүрт ижил нөхцөл, боломж, тэнцүү хугацаа ногдохоор тооцож, сонгуулийн сурталчилгаа эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална гэж хуульчлах.

31. Радио, телевизээр нэвтрүүлж буй сонгуулийн сурталчилгаанд хяналт тавих, хариуцлага тооцох, аливаа этгээд хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудас ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сонгуулийн хууль тогтоомжийг мөрдөж ажиллаж байгаа эсэхэд Шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавьж, дүгнэлт гаргадаг байх. Мөн тухайн дүгнэлтийг үндэслэн эрх бүхий байгууллагаас холбогдох хариуцлагыг тооцох зохицуулалтыг хуульчлах.

Долоо. САНАЛ АВАХ, ДҮН ГАРГАХ ТАЛААР

32. Сонгуулийн тухай хуулиудад зааснаар нам, эвсэл, нэр дэвшигчээс томилогдсон ажиглагчид санал хураалтын дүнгийн тайлан мэдээг гаргуулан авах эрхтэй байдаг. Гэтэл сонгуулийн хороод санал хураалтын дүнг албан ёсоор нэгтгэж, Сонгуулийн Ерөнхий Хороо олон нийтэд албан ёсоор мэдээлээгүй байхад ажиглагчид болон нэр дэвшигч зэрэг бусад субъектээс санал хураалтын дүнгийн талаар мэдээлэх, зориуд буруу ташаа мэдээллийг олон нийтэд түгээх зэрэг үйлдэл гардаг. Иймд Сонгуулийн Ерөнхий Хорооноос санал хураалтын дүнгийн талаар албан ёсны мэдээлэл гаргаагүй байхад аливаа этгээд санал хураалтын дүнгийн талаар мэдээ, мэдээлэл түгээхийг хориглож, холбогдох хариуцлагыг хуульчлах шаардлагатай.

33. Сонгуулийн хэсгийн хороод санал хураалтын дүнг нэгтгэж тогтоол гаргах, түүнийг дээд шатны сонгуулийн хороондоо хүргүүлж, нэгтгүүлэх зэрэг ажиллагаа нь сонгуулийн бүрэн автоматжуулсан системийг ашиглаж байгаа тохиолдолд ач холбогдол багатайгаас гадна цаг хугацааны хувьд удах зэрэг сөрөг талтай байдаг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.4-д Саналыг санал тоолох төхөөрөмжөөр тоолох бөгөөд санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүн мэдээ нь тухайн хэсгийн санал хураалтын дүн байна гэж хуульчилсан нь чухал ач холбогдолтой бөгөөд сонгуулийн дүн мэдээтэй холбоотой элдэв маргаан, зөрчлөөс сэргийлэх ач холбогдолтой зохицуулалт болохыг анхаарч хуулийн төсөлд тусгах нь зүйтэй.

34. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух бүртгэлтэй сонгогч өөрийн харъяалах хэсгийн хороондоо хүсэлтээ гаргаж зөөврийн битүүмжилсан саналын хайрцгаар саналаа өгөх боломжтой байдаг. Гэтэл хэвтэн эмчлүүлж байгаа эмнэлэг нь өөрийнх нь байнга оршин суугаа газарт харъяалагдахгүй сонгогч тухайн эмнэлгийг харьялах

сонгуулийн хэсгийн зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдэн саналаа өгөх боломжгүй байдаг. Иймд санал авах өдөр өөрийн харъяа хэсгийн хороонд саналаа өгөх боломжгүй буюу эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа, хөдөө орон нутагт ажиллаж байгаа иргэдийн сонгох эрхийг эдлүүлж, саналыг нь авах талаарх хуулийн зохицуулалт шаардлагатай байгааг анхаарч үзэх нь зүйтэй.

35. Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байх, харааны бэрхшээлтэй сонгогчдыг саналаа хэрхэн өгөх талаарх гарын авлагаар хангах, сонгуулийн талаарх мэдээ, мэдээллийг телевизээр нэвтрүүлэхдээ дохионы хэлний орчуулгатай нэвтрүүлэх зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгох эрхийг хангах талаарх хуулийн зохицуулалтыг сонгуулийн хуулиудад тусгах.

36. Хэсгийн хороо зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдыг байнга оршин суугаа газрын сонгуулийн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтаас хасуулах асуудлыг Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгддэг байх зохицуулалтыг хуульчлах. Ингэснээр нэг сонгогч 2 хэсэгт санал өгөх эрсдлээс урьдчилан сэргийлнэ.

37. Архинаас гаргах албадан эмчилгээний газар болон эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа сонгогчид, асрамжийн газарт байдаг харж хандах хүнгүй болсон өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй иргэд /сонгуулийн эрх бүхий иргэд/-ээс тухайн эмнэлэг, асрамжийн газрыг харьяалж байгаа сонгуулийн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдэж зөөврийн битүүмжилсэн хайрцгаар саналаа өгөх хүсэлтийг сонгууль бүрт гаргадаг ч сонгох эрхээ тэр бүр эдэлж чаддаггүй талаар гомдол мэдүүлдэг. Иймд эдгээр сонгогчдын нэрсийг тухайн эмнэлэг, асрамжийн газрын удирдлагаас хэсгийн хороонд тодорхойлолт болон сонгогчдын нэрийн жагсаалтын маягтаар гаргаж өгөх, тухайн хэсгийн хороо тэдгээр сонгогчдын нэрсийг байнга оршин суугаа газрын сонгуулийн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтаас хасуулах асуудлыг Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаж, давхар санал өгөхөөс сэргийлэх зохицуулалтын хамт хуульчлах нь зүйтэй байна.

38. Олон хүн нэг дор ажилладаг уул уурхайн компани болон худалдаа наймаа төвлөрсөн хилийн боомт зэрэг газруудад сонгуулийн хэсэг байгуулж, хэсгийн хороо тэдгээр сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэж, сонгогчдын нэрсийг байнга оршин суугаа газрын сонгуулийн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтаас хасуулах асуудлыг Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаж, нэг сонгогч 2 санал өгөх эрсдлээс сэргийлэх зохицуулалтын хамт хуульчлах нь зүйтэй байна. Дээрх арга хэмжээг хуулийн хүрээнд нарийвчлан зохицуулснаар сонгогчдын ирц тодорхой хувиар нэмэгдэх боломжтой юм.

39. Ээлжит сонгуулиас бусад /нөхөн, дахин/ сонгуульд сонгуулийн автоматжуулсан систем хэрэглэх эсэх асуудлыг хуулиар зохицуулах, хэрэглэх тохиолдолд аль ч сонгуульд санал хураалтын дүн нь санал тоолох төхөөрөмжөөс

гарсан дүн байх, хэрэглэхгүй тохиолдолд хэсгийн хорооноос санал хураалтын дүнгийн тухай ямар баримт гарч, ямар хэлбэрээр баталгааждаг байх талаар хуульчлах. Учир нь сумдад явагдаж байгаа Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгууль бүрээр Улсын Их Хурлаас шийдвэр гаргуулах боломжгүй байдаг.

40. Санал тоолох төхөөрөмжөөс гарах тайлангийн мэдээллийг Сонгуулийн Ерөнхий Хорооноос баталдаг байх. Батлагдсан мэдээллийн дагуу тайланг хэвлэдэг байх.

41. Гадаад улсад байгаа иргэдээс санал авах, санал тоолох ажиллагааг ямар журмаар зохион байгуулж явуулах талаар хуульд нарийвчлан тусгах.

42. Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчийн 50 хувь нь сонгуульд оролцоогүй бол нэмэлт болон дахин санал хураалт явуулдаг зохицуулалтыг хуулиас хасах. Санал хураалтын ирцийг санал хураалтад оролцсон сонгогчдын ирцийн хувиар хүчинтэйд тооцдог байхаар хуульчлах. Учир нь өмнөх сонгуулиудаар явагдаж байсан дахин санал хураалтын ирц анхны санал хураалтын ирцээс нэмэгдэж байсан нэг ч тохиолдол гарч байгаагүй бөгөөд санал хураалтын дүн ч өөрчлөгдөж байсан тохиолдол цөөн юм. Ирцээс шалтгаалсан дахин болон нэмэлт санал хураалт нь цаг, мөнгө, хөлс хүч дэмий үрсэн, улс төржих шалтаг үүсгэдэг сул талтайг анхаарах нь зүйтэй юм. Түүнчлэн бусад хөгжингүй орнуудын сонгууль зохион байгуулж буй туршлагаас үзэхэд сонгуульд оролцсон сонгогчдын ирцээр санал хураалтын дүнг тооцож гаргадаг нийтлэг зохицуулалт байдаг.

Найм. ДАХИН СОНГУУЛЬ ЯВУУЛАХ, ДАХИН БОЛОН НЭМЭЛТ САНАЛ ХУРААЛТЫН ТАЛААР

43. Саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэлд юу хамаарахыг аль ч сонгуульд нэг ижил хуульчлах. Тухайлбал, зөвхөн баталсан загвар, шаардлага хангаагүй саналын хуудсыг хүчингүй саналын хуудаст тооцдог байх нь зүйтэй байна. Сонгогч саналын хуудсанд саналаа тэмдэглэхдээ ямар тэмдэглэгээ хийх нь тухайн сонгогчийн эрхийн асуудал тул зааварт зааснаас өөр тэмдэглэгээ хийсэн саналын хуудсыг хүчингүйд тооцдог зохицуулалтыг хуулиас хасах нь зүйтэй байна.

44. Сонгуулийн Ерөнхий Хорооны 2012 оны 127 дугаар тогтоолд зааснаар санал тоолох төхөөрөмжид уншигдсан бүх саналын хуудсыг хүчинтэй саналын хуудаст тооцдог байх гэж хуульчлах. Учир нь санал тоолох төхөөрөмж баталсан загварын бус, шаардлага хангаагүй саналын хуудсыг уншихгүй буцаах тул санал тоолох төхөөрөмжөөс хэвлэгдэх тайланд хүчингүй саналын хуудасны тоо "0" гэж гардаг. Иймд хуульд заасан санал хураалтын дүн гаргах үзүүлэлтэд санал тоолох төхөөрөмжид уншигдсан саналын хуудасны тоо гэсэн үзүүлэлтийг нэмж хуульчлах. Ингэснээр санал тоолох төхөөрөмжид уншигдсан саналын хуудасны тоо болон хүчинтэй саналын хуудасны тоо ижил гэдгийг тайлангаас харах боломжтой бөгөөд үүнтэй холбогдсон эргэлзээ, ойлголтын зөрүү арилна.

45. Санал авахад зарцуулсан болон зарцуулагдаагүй үлдсэн саналын хуудасны нийлбэр нь тухайн хэсгийн хороо хүлээн авсан нийт саналын хуудасны тооноос зөрвөл хэсгийн хороо саналын хуудсыг нэн даруй дахин тоолдог. Энэ нь санал дахин тоолох үндэслэл болохгүйг хуульчлах.

46. Хяналтын тооллого хийх журмыг хуульд нарийвчлан зохицуулах шаардлагатай байна. Ингэснээр саналын хуудсуудыг саналын хайрцгаас гаргаж санал тоолох төхөөрөмжийн дүнтэй хэрхэн тулгаж тоолох ажиллагааг тодорхой болгох, улмаар хяналтын тооллогын дүнг улсын хэмжээнд нэг аргачлалаар тооцож гаргах ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл, саналын хайрцгаас хүчингүй саналын хуудас гарахгүй, зааварт зааснаас өөр тэмдэглэл хийсэн саналын хуудсыг хүчингүйд тооцохгүй, намд өгсөн санал нь хүчинтэй, нэр дэвшигчид өгсөн санал нь хүчингүй санал бүхий саналын хуудсанд тэмдэглэгдсэн саналуудыг ялгамжтай авч үзэх гэх мэт болно.

47. Улсын Их Хурлын гишүүнээр хамгийн олон, гэхдээ санал өгсөн сонгогчдын тодорхой хувиас дээш хувийн санал авсан мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр шууд сонгогдсонд тооцдог зохицуулалтыг хэвээр хадгалж, одоогийн санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал гэсэн босгыг багасгаж 20-25 хувь болгох. Учир нь санал өгсөн сонгогчдын 28 ба түүнээс дээш хувийн санал гэдэг нь тойрог бүрт сонгогчдын тооноос хамаарч харилцан адилгүй байдгийг харгалзан үзэх шаардлагатай. Харин санал өгсөн сонгогчдын хувийг хасч босгогүй болгон хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцохоор хуульчилбал санал хураалтын дүнгийн болоод нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасуулахтай холбогдсон сонгуулийн маргаан тухайн тойрогт нэр дэвшсэн олон нэр дэвшигчийн хооронд үүсэх магадлалтайг анхаарах шаардлагатай.

48. Аль ч сонгуульд дахин санал хураалт явуулах үндэслэл, журмыг нарийн тодорхойлох шаардлагатай байна. Тухайлбал, санал тэнцсэн, санал өгсөн сонгогчдын тодорхой хувийн санал аваагүй нэр дэвшигчдийг дахин санал хураалтад оруулах шийдвэрийг Улсын Их Хурлын сонгуулийн хувьд Сонгуулийн Ерөнхий Хороо гаргадаг байх. Энэ тохиолдолд дахин санал хураалтад зөвхөн нэр дэвшигчдийн нэр бүхий саналын хуудсаар санал хураадаг байх. Харин хэсэгт явуулсан санал хураалтыг хуульд заасан үндэслэлээр хүчингүйд тооцвол нам, эвсэл, нэр дэвшигчдийн нэр бүхий саналын хуудсаар дахин санал хураадаг байх.

49. Нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулж явуулах хугацаа болон бусад зохион байгуулалтын үйл ажиллагааг нарийвчлан зохицуулах нь зүйтэй байна. Учир нь сонгуулийн хуулиудад эдгээр сонгуулийг зохион байгуулж явуулах талаар нарийвчилсан зохицуулалтууд тусгагдаагүй байдаг. Тухайлбал, нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх, нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэх, дуусах, нэр дэвшигчийг бүртгэх, сонгуулийн сурталчилгаа явагдах, сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, сонгуулийн хороодод хүргүүлэх, сонгуулийн автоматжуулсан систем хэрэглэхгүй тохиолдолд сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний бүртгэлийн

байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгч хөтлөх эсэх, санал тоолох ажиллагааг ямар журмаар зохион байгуулах, саналын хуудас хэвлүүлэх, хүргүүлэх зэрэг ажиллагааг ямар хугацаанд хийж гүйцэтгэх талаар тодорхой заах.

50. Сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөх гэдгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2 дахь хэсэгт зааснаар хуульчлах нь зүйтэй байна.

51. Сонгуулийг хосолсон тогтолцоогоор зохион байгуулж байгаа тохиолдолд тухайн хэсэгт дахин санал хураалт явуулахаар шийдвэрлэсэн бол ямар үндэслэлээр дахин санал хураалт явуулж байгаагаас хамаарч дахин санал хураалтын саналын хуудсанд намын нэр бичигдэх асуудлыг тодорхой болгон хуульчлах. Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын 2012 оны сонгуулиар нийслэлийн Сүхбаатар дүүрэгт санал өгсөн сонгогчдын ирц 50 хувьд хүрээгүй гэдэг үндэслэлээр явагдсан дахин санал хураалтын саналын хуудсанд нэр дэвшигчээс гадна намын нэрийг бичиж санал хураасан тохиолдол гарч байсан. Өөрөөр хэлбэл, тойргийн хэмжээнд санал өгсөн сонгогчдын ирц нэгэнт 50 хувьд хүрсэн бол тухайн хэсэгт явагдах дахин санал хураалтад намын нэр дээр дахин санал хураах шаардлагагүй юм. Иймд уг асуудлыг нэг мөр хуульчилж цаашид ойлголтын зөрүүгээс болж хууль зөрчигдөх шалтгаан гаргахгүй байх нь зүйтэй байна.

Ес. СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА, ГОМДОЛ МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР

52. УИХ-ын гишүүнээр сонгогдсонд тооцогдсон нэр дэвшигчид УИХ-ын гишүүний түр үнэмлэх олгодог. Уг үнэмлэхийн хүчинтэй хугацааг тухайн нэр дэвшигчийг УИХ-ын гишүүний тангараг өргөснөөр дуусгавар болсонд тооцдог байхаар хуульчлах шаардлагатай байна. Учир нь “нэр дэвшигч” хэмээх сонгуулийн эрх зүйн харилцаанд оролцож байгаа этгээдэд холбогдох маргааныг нэр дэвшигчид хуулиар олгогдсон эрх, үүрэг дуусгавар болохоос өмнө буюу УИХ-ын гишүүний тангараг өргөхөөс өмнө эрх бүхий этгээдээс хянан шийдвэрлэдэг байх нь зүйтэй байна. Үүнтэй холбогдуулан сонгуулийн гомдол, маргааныг шүүхээс хянан шийдвэрлэх хугацааг сонгуулийн хууль тогтоомжид тусгайлан зааж өгөх нь зүйтэй байна. Нэр дэвшигч УИХ-ын гишүүний тангараг өргөж УИХ-ын гишүүн болсны дараа маргаан үүсгэж шийдвэрлэх боломжгүй байх. Бусад сонгуульд үүнтэй адил зарчмыг баримтлах. Өмнөх сонгуулийн хуулиудад сонгуулийн, маргаан зөрчлийн төрлийг нарийвчлан тодорхойлоогүй, маргааны хариуцлагын төрлөөс хамаарч түүнийг хянан шийдвэрлэх субъектийг зааж өгөөгүйгээс үүдэн сонгуультай холбогдон гарсан бүхий л маргааныг тойргийн хороо харъяалан шийдвэрлэж байсан. Энэ нь аливаа гомдол маргааныг шийдвэрлэхэд хугацаа алдах, шийдвэрлэгдэхгүй удах зэрэг сөрөг үр дагавартай байсан. Сонгуулийн хороод нь төрийн нэрийн өмнөөс сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулж, явуулах зорилгоор байгуулагддаг, ажиллах хугацаандаа нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн шийдвэр гаргаж нийтийн эрх зүйн харилцаанд оролцдог, нийтийн захиргааны байгууллага тул захиргааны эрх зүйн субъект юм. Хэдийгээр сонгуулийн хуулиудад сонгуулийн маргааныг шүүхээр харъяалан шийдвэрлэхээр

хуульчлаагүй ч эцсийн дүндээ сонгуулийн маргаан шүүхэд хүрч шийдэгдэх нөхцлийг бүрдүүлж байсан. Энэ тодорхой бус зохицуулалт нь сонгуулийн маргаан он дамжин шийдвэрлэгдэхгүй удах үндсэн нөхцөл болж байна. Харин шинэчлэгдэн батлагдсан Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд зааснаар сонгуулийн хороодын бүрэлдэхүүн, үйл ажиллагаатай холбоотой гомдлоос бусад гомдол маргааныг тухайн нутаг дэвсгэрийн харъяалах захиргааны хэргийн шүүх шийдвэрлэхээр хуульчилсан. Иймд сонгуулийн маргаан, түүнийг хянан шийдвэрлэх зөв процесс, шаардлагатай. Сонгууль бол тодорхой тогтоосон хугацаанд явагдаад өнгөрдөг онцлогтой. Энэ онцлогт нь тохируулсан маргаан шийдвэрлэх хугацаа, механизмтай байх ёстой. Мөн сонгуулийн хороодын шийдвэрийг шүүх түдгэлзүүлэх нь иргэний сонгох, сонгогдох эрхийн зарчимд нийцэж буй эсэхийг нухацтайгаар авч үзэх шаардлагатай байна.

53. Санал хураалтын дүнтэй холбогдсон гомдол, маргааныг аймаг, нийслэлийн сонгуулийн хороо 14 хоногийн дотор заавал шийдвэрлэдэг байх талаар хуульчлах. Зохих шатны сонгуулийн хорооноос санал хураалтын дүнтэй холбогдсон гомдол, маргаан шийдвэрлэсэн бол шийдвэр гаргадаг байх. Энэ үүргээ биелүүлээгүй бол тухайн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд багтаж байгаа төрийн албан хаагчдыг төрийн албанд эргэж орох эрхгүйгээр тодорхой хугацаагаар ажлаас халах хариуцлага ногдуулдаг байх нь зүйтэй байна. Учир нь өмнөх олон удаагийн сонгуулиар зохих шатны сонгуулийн хороод маргаан шийдвэрлэх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй эс үйлдэхүйн улмаас дээд шатны сонгуулийн хороонд эрх үүрэг нь шилжиж ирсэн тохиолдлууд байдаг.

54. Сонгуулийн гомдол, маргаан шийдвэрлэх харьяалал, журмыг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай байна. Тухайлбал, шат шатны сонгуулийн хороо тус бүрийн шийдвэрлэх гомдол, маргаан, хуулиар харьяалуулсан бусад байгууллагын шийдвэрлэх гомдол, маргаан, шүүхийн шийдвэрлэх гомдол, маргаан, түүнийг шийдвэрлэх хугацааг тодорхой заах.

55. Сонгуулийн хууль тогтоомжоор зохицуулж байгаа харилцаа тус бүрийг хуулийн холбогдох бүлэг тус бүрт зохицуулах шаардлагатай байгаа бүх харилцааг орхигдуулалгүй бүрэн тусгаж, эмх цэгцтэй болгох шаардлагатай байна.

56. Сонгуулийн тойргийн хороонд холбогдуулан үүсгэсэн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Сонгуулийн Ерөнхий Хороо тойргийн хорооны эрхийг залгамжилж орох үндэслэлтэй эсэх асуудалд дүгнэлт өгч хуульчлах шаардлага зайлшгүй урган гарч байна. Уг асуудлаар Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2013 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 61 дүгээр тогтоолын үндэслэх хэсэгт "...тойргийн хорооны үйл ажиллагаатай холбогдуулан үүсгэсэн захиргааны хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд Сонгуулийн Ерөнхий Хороо хариуцагч тойргийн хорооны эрх залгамжлагчаар оролцсон нь Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.5 дахь заалтад нийцээгүйг дурьдах нь зүйтэй" гэсэн дүгнэлт хийсэн байдаг. Иймд Сонгуулийн Ерөнхий Хороо нь тойргийн хорооны бүрэн

эрхийг шүүхэд төлөөлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх залгамжлагчаар оролцохгүй байхыг хуульчлах нь зүйтэй.

57. Бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн Улсын Их Хурлын гишүүн болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийг эгүүлэн татахтай холбогдсон харилцааг Улсын Их Хурлын тухай хууль болон Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуульд зааснаар зохицуулах гэж хуульчлах.

Арав. БУСАД

58. Сонгуулийг автоматжуулсан системээр зохион байгуулж байгаа тохиолдолд ялангуяа аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулиар сонгуульд нэр дэвшигчдийн нэрсийг Сонгуулийн Ерөнхий Хороонд гаргаж өгөх эцсийн хугацааг хуульд нарийвчлан тусгах, хугацаа хэтрүүлсэн тохиолдолд холбогдох этгээдэд ногдуулах хариуцлагыг хуульчлах. Учир нь аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2012 оны сонгуулиар зарим сонгуулийн хороод нэр дэвшигчдийн нэрийг саналын хуудас хэвлүүлэх ажиллагаа эхэлсний дараа, зарим нь хэвлэгдсэний дараа шинээр нэр дэвшигчийн нэрийг нэмж бичүүлэх шаардлага тавьж сонгууль зохион байгуулах ажилд хүндрэл учруулж байсан. Мөн зарим нэр дэвшигчийн нэрийг саналын хуудаст бичилгүйгээр санал хураалт явуулсан тохиолдол гарч байсан. Үүнтэй холбоотой маргааныг шүүх хянан шийдвэрлэж дахин санал хураалт явагдах нөхцөл байдал үүсч байсан.

59. Сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад сонгуулийн хороонд ажилласан хугацааны цалин хөлсийг үндсэн байгууллагаас нь олгох тухай хуулийн зохицуулалттай боловч тухайн сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа зарим төрийн албан хаагчид ээлжийн амралтынхаа хугацаанд сонгуулийн хороонд ажилладаг тохиолдол гардаг. Иймд ээлжийн амралтынхаа хугацаанд сонгуулийн хороонд ажиллаж байгаа төрийн албан хаагчдад үндсэн байгууллагаас нь цалингийнх нь тодорхой хувийг олгодог байхаар хуульчлах. Ингэснээр тухайн төрийн албан хаагчийг сонгуулийн хороонд тогтвортой, хариуцлагатай ажиллахад нөлөөлнө гэж үзэж байна.

60. Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1-д “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах...” гэж хуульчилсан учир Улсын дээд шүүхээс сонгуулийн хуулийн зарим зүйл, заалтыг шууд тайлбарлах боломжгүй байна. Иймд сонгуулийн нэгдсэн хуульд нэр томъёоны болон зарим зүйл, заалтын талаарх тайлбарыг томъёолж, хуульд тусгаснаар сонгуулийн хуулийг эргэлзээгүй, нэг мөр, зөв ойлгож хэрэглэхэд ач холбогдолтой.

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО